



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/567

Булган сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн болон сайжруулсан үхрийг бүртгэлд хамруулж мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Н.Пүрэвсайхан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Гишүүд: А.Ганхуяг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Д.Сэрчлхам (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн улсын хяналтын байцаагч)

Б.Гансүх (Тэшиг сумын Засаг дарга)

Ж.Ууганбаяр (Хутаг-Өндөр сумын Засаг дарга)

А.Ганбагана (Сэлэнгэ сумын Засаг дарга)

С.Ичинхорлоо (Хангал сумын Засаг дарга)

Х.Ууганбаяр (Бугат сумын Засаг дарга)

Х.Ундрахбаяр (Орхон сумын Засаг дарга)

Б.Ёндон (Баяннуур сумын Засаг дарга)

Д.Бямбажав (Булган сумын Засаг дарга)

Ш.Болдбаатар ("Хужирын адаг" ХХК-ийн захирал)

М.Галдан ("Хөгнө мээж" ТББ-ын менежер)

Н.Уянга ("Их арвижин дэлгэрэх" ХХК-ийн захирал)

Булган сум 2025 оны 09 сарын 01 өдөр

6325010779

Нарийн бичгийн дарга: М.Жавзандолгор (Хүнс, хөдөө аж ахуйн газрын
Мал аж ахуйн хэлтсийн дарга)

2. Өндөр ашиг шимтэй цэвэр үүлдрийн болон сайжруулсан үхрийг ялган тэмдэглэх, бүртгэлд хамруулж мэдээллийн сан бүрдүүлэх ажилд хүн хүч, машин техник болон санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. “Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэх өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн болон сайжруулсан үхрийг бүрэн хамруулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж, технологийн хугацаанд үр дүнтэй шуурхай зохион байгуулахыг ажлыг хэсэг (Н.Пүрэвсайхан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

